



**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МАТЕРИАЛ**



2024 оны 04-р сарын 27

МЭНДЧИЛГЭЭ

“ТҮМЭН ШУВУУТ “ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ!

Бид өнгөрөгч 2023 онд бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн бүтээмжээ нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөтгөн амжилттай ажиллалаа. Хувьцаа эзэмшигч Та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг нэгтгэн хүргэж байна. “Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14:00 цагт “Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал”-ын “Соёмбо” танхимд хуралдана.

ХӨТӨЛБӨР

1. Панел хэлэлцүүлэг:

Илтгэгчид - Л.Эрхэмбаяр “Нууцаа хуваалцья” -10 мин

- Х.Хатанбаатар “Амжилтад хүргэх ур чадвар” -15 мин

- Г.Мөнх-Эрдэнэ “Түмэн шувуутын ханш хэзээ сэргэх вэ?” -10 мин

- А.Идэрбат “Хувьцааны зөв сонголт” - 10 мин

- С.Идэр “Хөрөнгөтөн” - 10 мин

2. “Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

3.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын зардлын төсөв батлах;

4. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх. Үүнд:

а.Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

б.“Түмэн шувуут-3” шувууны аж ахуйн танилцуулга, мэдээлэл

Хувьцаа эзэмшигч Та өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол төлөөлөх хүндээ итгэмжлэх бичиж, нотариатаар гэрчлүүлсэн байна. Саналын хуудсаар урьдчилан санал өгөх бол үнэт цаасны компаниар дамжуулан 2024 оны 04 сарын 27-ний өдрийн 14.00 цагаас өмнө саналаа ирүүлнэ үү.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН
27-НЫ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

№	Хурлын дэг	Шийдвэрийн төсөл	Танилцуулах албан тушаалтан	Хугацаа
1	Хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэх	-	Зохион байгуулах комисс	13:30-13:55
2	Бүртгэлийн ажиллагааны дүнг танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	Тооллогын комиссын дарга Б.Урантунгалаг	13:55-14:00
3	Хурлын дарга хурлыг нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулах	-	ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр	14:00-14:05
	3.1 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах	-	Гүйцэтгэх захирал Ж.Болд	14:05-14:15
	3.2 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн галаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр	14:15-14:20
	3.3 “Түмэн шувуут” ХК-ийн ирээдүй сэдэвт илтгэл	Мэдээлэл өгөх	ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр	14:20-14:35
	3.4 Ногдол ашгийн мэдээлэл өгөх	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр	
	3.5 Цайны завсарлага			14:35-14:45
	3.6 Панел хэлэлцүүлэг	Мэдээлэл өгөх		14:45-15:45
	3.7 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох /танилцуулга явах/	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр	15:45-16:15
3.8 ТУЗ-ийн цалин, урамшууллын зардлын төсөв батлах тухай	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлах	ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр	16:15-16:25	
4	Асуулт, хариулт			16:25-16:55
5	Саналын хуудсаар саналаа өгөх /цахимаар/, бөглөх санамж өгөх	-	hural.tumenshuvuut.mn сайтаар	16:55-17:05
6	Санал тоолох ажиллагаа	-	Тооллогын комисс	17:05-17:15
7	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	Тооллогын комиссын дарга Б.Урантунгалаг	17:15-17:20
8	Хурал хаах	-	ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр	17:20-17:25

Санал хэлэх гишүүн гар өргөж, хурлын даргаас зөвшөөрөл авч санал хэлнэ.
Хэлэлцэх асуудлаар 1 гишүүн 1 удаа 3 минутын хугацаанд санал шүүмжлэл хэлнэ.



“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 18-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2, 9 дүгээр зүйлийн 9.6.13, 9.12, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 4 дүгээр бүлгийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Түмэн шувуут” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14:00 цагт “Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал”-ын “Соёмбо” танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 03 сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 03 сарын 22-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 04 сарын 08-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 03 сарын 27-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ж.Болдод үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Эрхэмбаярыг томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
 1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
 1. Гүйцэтгэх захирал Ж.Болд
 2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
 1. Н.Должинсүрэн
 2. Б.Мөнгөнтуяа
 3. Б.Нямбаяр
 4. Ж.Уянга
 5. С.Дуламсүрэн
8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн санал хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14:00 цаг байхаар тогтоосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Ж.Болд/-т даалгасугай.

11. Хурлын тооллогын комиссыг дараахи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

1. Хурлын тооллогын комиссын дарга:
 1. Б.Урантунгалаг
2. Хурлын тооллогын комиссын гишүүд:
 1. Э.Уянга
 2. З.Өнөрсайхан
 3. Н.Уранчимэг
 4. Б.Отгонсүвд

12. Компанийн дүрмийн 8.12.4-т зааснаар санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах, үүнд санал хураалтанд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр гүйцэтгэх, хуралд оролцогч бүрийн өгсөн саналыг хэвлэж, үнэн зөв болохыг баталгаажуулж, компанид хүлээлгэж өгөх үүрэг хүлээх зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ж.Болдод үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 03 сарын 18-ны өдрийн 05 тоот
тогтоолын Гэсгүүгээр хавсралт



**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГС АЛТ**

“Түмэн шувуут” Хувьцаат Компанийн 2024 оны 04 сарын 27-ны өдөр болох Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. “Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх. Үүнд:
 - a. “Түмэн шувуутын ирээдүй” сэдэвт илтгэл
 - b. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
 - c. “Түмэн шувуут-3” шувууны аж ахуйн танилцуулга, мэдээлэл
 - d. Панел хэлэлцүүлэг хийх
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын зардлын төсөв батлах;

-----oOo-----

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 03 сарын 18-ны өдрийн 27 тоот
тогтоолыг хэргээрээр хавсралт



**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №1**

Хувьцаа эзэмшигчийн/оноосон нэр/ овог.....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

регистрийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо:

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

“Түмэн шувуут” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14.00 цагт “Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал”-ын “Соёмбо” танхимд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	“Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын зардлын төсөв батлах			

(Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт + тэмдгийг бичнэ үү.)

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

Брокер Гарын үсэг

/ тэмдэг /

2024 оны..... сар.....өдөр

САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад саналын хуудсаар саналаа өгч болно.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
3. Засварласан болон балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 70005225 утсаар авлаж болно.
5. Саналын хуудас хүчингүйд тооцсон бол түүний үндэслэл

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 03 сарын 18-ны өдрийн 05 тоот
тогтоолын Хоёрдугаар хэсэрт



**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №2**
(ТУЗ-ийн гишүүн сонгох)

Хувьцаа эзэмшигчийн/оноосон нэр/ овог.....нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

регистрийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо:

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

ТУЗ-ийн гишүүнийг сонгоход хэрэглэх санал хураах арга: Кумулятив

“Түмэн шувуут” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14.00 цагт “Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал”-ын “Соёмбо” танхимд болно.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
<i>Ердийн гишүүн</i>		
1.		
2.		
3.		
4.		
5.		
6.		
<i>Хараат бус гишүүн</i>		
1.		
2.		
3.		
4.		
5.		

6.		
7.		
8.		
9.		
10.		
11.		

(Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: А. Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй ($100 \times 9 \text{ гишүүн} = 900$) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй. Б. Хувьцаа эзэмшигч та нийт саналын эрхээ бүгдийг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно гэдгийг анхаарна уу.)

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

2024 оны..... сар.....өдөр “

САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад саналын хуудсаар саналаа өгч болно.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
3. Засварласан болон балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 70005225 утсаар лавлаж болно.
5. Саналын хуудсыг хүчингүй болгосон бол түүний үндэслэл
.....

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 03 сарын 18-ны өдрийн 05 тоот
тогтоолын Гурвандугаар хавсралт



“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

Хурал болох газар: “Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал”-ын “Соёмбо” танхимд
Хурал болох өдөр, цаг: 2024 оны 04 сарын 27-ны өдрийн 14:00 цагт
Компанийн оноосон нэр: “Түмэн шувуут” ХК

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх. Үүнд:
 - a. “Түмэн шувуутын ирээдүй” сэдэвт илтгэл
 - b. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
 - c. “Түмэн шувуут-3” шувууны аж ахуйн танилцуулга, мэдээлэл
 - d. Панел хэлэлцүүлэг хийх
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын зардлын төсөв батлах;

Бүртгэлийн өдөр: 2024 оны 04 сарын 09-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тухай тайлан;
2. 2023 оны санхүүгийн тайлангийн талаархи аудитын дүгнэлт;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
5. Саналын хуудас;
6. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ын хурлын 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 02/2024 тоот тогтоол;
7. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт;

Хувьцаа эзэмшигчид өөрийн харилцагч үнэт цаасны компани, хурал зохион байгуулах комисстой холбогдож, эсхүл компанийн цахим хуудсаар дамжуулан хурлаар хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж болно.

Хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй Даваагаас Баасан гаргуудад 09-17 цагийн хооронд дор дурдсан хаяг, утсаар холбогдох боломжтой.

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, 21 дүгээр хороолол, 59 дүгээр байшин, “Түмэн шувуут” ХК-ийн оффис

Харилцах утас: 976-70005225, 80077043

Цахим шуудан: narantsetseg.d@tumenshuvuut.mn

Хурал зохион байгуулах комисс

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 03 сарын 18-ны өдрийн 02 тоот
тогтоолын Дөрөвдүгээр хавсралт



**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД
БЭЛТГЭХ ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ
БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тухай тайлан;
2. 2023 оны санхүүгийн тайлангийн талаархи аудитын дүгнэлт;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
5. Санал авах хуудас;
6. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ын хурлын 2024 оны 02 сарын 19- ны өдрийн 02/2024 тоот тогтоол
7. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

Дэд бүлэг 1



ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Түмэн Шувуут ХК-ийн Хувьцаа эзэмшигчид танаа,

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**Дүгнэлт**

Бид Түмэн Шувуут ХК болон түүний охин компаниуд (хамтад нь "Групп" гэх)-ийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Группийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний нэгтгэсэн санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЕЗОУС3-ын дүрэм" гэх)-ийн дагуу Группээс хараат бус ба НБЕЗОУС3-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн үнэлэмжээр Аудитын гол асуудал нь тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой, нөлөө бүхий асуудал юм. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудал бүрт тусад нь дүгнэлт гаргаагүй болно. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

Аудитын гол асуудлууд**Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд****Биологийн хөрөнгийн үнэлгээ**

СТОУС-ын дагуу биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хасч тооцсон бодит үнэ цэнээр нь хэмжиж, тайлагнахыг шаарддаг хэдий ч Группийн биологийн хөрөнгийн хувьд бодит үнэ цэнийг нь тодорхойлох идэвхтэй зах зээл, харьцуулах мэдээлэл байхгүй тул Группийн биологийн хөрөнгийг хуримтлагдсан хорогдол болон үнэ цэнийн бууралтыг хассан өртгөөр нь хэмжсэн. Хорогдуулгын түвшинг тухайн биологийн хөрөнгөөс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хүлээн авах хугацааг үндэслэн тооцоолж, шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

2023 оны 12-р сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд 4,781,161 мянган төгрөг (2022 оны 12-р сарын 31: 3,651,258 мянган төгрөг)-ийн биологийн хөрөнгө тусгагдсан. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 13-г үзнэ үү.

Биологийн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Биологийн хөрөнгийн үнэлгээг тодорхойлох дотоод процессын талаар ойлголт олж авч, холбогдох хяналтын үр ашигтай байдлыг үнэлсэн;
- 2023 оны 12-р сарын 31-нээрх биологийн хөрөнгийн хувьд түүврийн аргаар холбогдох өртгийг анхан шатны баримт руу шалгасан;
- Биологийн хөрөнгийн үнэлгээг тодорхойлоход ашигласан удирдлагын гол таамаглалын талаар удирдлагаас тайлбар авсан;
- Биологийн хөрөнгийн хорогдлын түвшинг тодорхойлсон удирдлагын тооцоолол болон үнэлэмжийн зохистой байдлыг үнэлсэн;
- Биологийн хөрөнгөтэй холбоотой нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгын бүрэн зөв, зохистой байдлыг үнэлсэн.

Onch & Company тухай

Onch & Company нь Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгэлтэй барааны тэмдэг юм. Энэхүү тэмдгийг Онч Аудит ХХК, Онч Зөвлөх үйлчилгээ ХХК, Онч Татварын Зөвлөх үйлчилгээ ТМЗ ХХК-иуд ашиглах эрхтэй бөгөөд тэдгээр нь аудит, эрсдэлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг Монголын харилцагчдад үзүүлдэг байгууллагууд юм.

© 2024. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Onch & Company-тай холбогдоно уу.

Бусад мэдээлэл

Группийн удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэлд агуулагдсан мэдээллүүд орох бөгөөд нэгтгэсэн санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт орохгүй. Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд өгсөн манай аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын ажлын хүрээнд олж мэдсэн мэдээллээс материаллагаар зөрүүтэй эсвэл зөрүүтэй мэт харагдаж байгаа эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бид хийсэн ажил дээрээ үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг алдаатай байна гэж үзвэл бодит мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй болно.

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Удирдлага санхүүгийн тайланг бэлтгэх үедээ Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, уг чадамжид нөлөөлөхүйц нөхцөл байдлын талаар шаардлагатай үед тодруулах болон Группийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг баримталсан болно. Мөн түүнчлэн:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай болон зохистой аудитын баримт, нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс өндөр байдаг. Учир нь залилан нь үгсэн тохирох, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, худал батламж гаргах болон дотоод хяналтыг зөрчих зэрэг явдлуудаас үүссэн байх магадлалтай байдаг.
- Бид Группийн дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус зөвхөн нөхцөл байдалд тохирох аудитын горимуудыг сонгох зорилгоор дотоод хяналтуудыг судалдаг.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлдэг.

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг (үргэлжлэл)

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцлийг үргэлжлүүлэн хангах Группийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг аудиторын дүгнэлтэнд тусгаж анхааруулах, мөн тэдгээр тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай байдаг. Бид дүгнэлтээ аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотлох баримтан дээр үндэслэн гаргадаг. Тиймээс ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Групп үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд саад учруулж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бүхэлд нь үнэлдэг ба ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахүйц байдлаар толилуулсан эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд Группийн доторх компаниуд болон бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээллийн талаарх зохистой аудитын нотолгоо олж авсан. Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэл болон түүнийг удирдан зохион байгуулахтай холбоотой үүргийг хүлээдэг. Мөн бид өөрсдийн аудитын дүгнэлтийн талаар үүрэг хүлээдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудын талаар мэдээлдэг ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын томоохон алдаа болон дутагдал орно.

Онч Аудит ХХК
Онч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
2024 оны 4-р сарын 9

Б. Анхтайван
Б. Анхтайван
Партнер, МНБ



**ТҮМЭН ШУВУУТ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12-Р САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6	1,450,661	624,651
Дансны ба бусад авлага	7	5,997,851	4,011,655
Урьдчилгаа төлбөр	8	4,490,059	1,361,682
Бараа материал	9	6,520,445	6,046,094
Биологийн хөрөнгө	13.1	2,893,041	2,260,048
		21,352,057	14,304,130
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	11	43,847,074	35,761,063
Биет бус хөрөнгө	12	534,033	363,842
Биологийн хөрөнгө	13.2	1,888,120	1,391,210
		46,269,227	37,516,115
Нийт хөрөнгө		67,621,284	51,820,245
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Дансны ба бусад өглөг	15	4,368,909	3,485,360
Гэрээний өр төлбөр	16	46,266	90,099
Орлогын албан татварын өглөг	21.2	1,282,263	637,176
Богино хугацаат зээл	17	4,080,366	5,465,291
		9,777,804	9,677,926
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат зээл	17	14,372,649	7,902,469
		14,372,649	7,902,469
Нийт өр төлбөр		24,150,453	17,580,395
Хувьцаа эзэмшигчдийн өмч			
Хувьцаат капитал	18	4,000,000	4,000,000
Нэмж төлөгдсөн капитал	19	8,007,687	8,007,687
Хуримтлагдсан ашиг		31,812,452	22,574,178
		43,820,139	34,581,865
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох өмч	20	(349,308)	(342,015)
Нийт өр төлбөр ба Эзэмшигчдийн өмч		67,621,284	51,820,245

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

**ТҮМЭН ШУВУУТ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
НЭГТГЭСЭН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
12-Р САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
Борлуулалтын орлого	22.1	63,812,887	46,321,708
Борлуулалтын өртөг	22.2	(59,094,410)	(43,108,420)
Нийт ашиг		4,718,477	3,213,288
Хөдөө аж ахуйн бүтэгдэхүүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бодит үнэ цэнийн олз	23	16,639,648	10,079,684
Бусад орлого		66,892	9,758
Санхүүгийн зардал	17.2	(1,003,175)	(700,186)
Борлуулалт ба ерөнхий удирдлагын зардал	24	(6,473,408)	(5,066,891)
Бусад олз ба (гарз)	25	(71,240)	(1,014,486)
Татварын өмнөх ашиг		13,877,194	6,521,167
Орлогын татварын зардал	21	(2,506,200)	(1,142,323)
Тайланг жилийн цэвэр ашиг		11,370,994	5,378,844
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Нийт дэлгэрэнгүй орлого		11,370,994	5,378,844
Группийн эздэд ногдох хэсэг		11,378,287	5,558,711
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох хэсэг	20	(7,293)	(179,867)
		11,370,994	5,378,844
Нэгж хувьцаанд ногдох ашиг		56.85	26.89

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

**ТҮМЭН ШУВУУТ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
12-Р САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт өмч
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,000,000	8,007,687	19,095,795	31,103,482	(162,148)	30,941,334
Тайланг жилийн цэвэр ашиг	-	-	5,558,711	5,558,711	(179,867)	5,378,844
Зарласан ногдол ашиг (Тодруулга 18)	-	-	(2,080,328)	(2,080,328)	-	(2,080,328)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,000,000	8,007,687	22,574,178	34,581,865	(342,015)	34,239,850
Тайланг жилийн цэвэр ашиг	-	-	11,378,287	11,378,287	(7,293)	11,370,994
Зарласан ногдол ашиг (Тодруулга 18)	-	-	(2,140,013)	(2,140,013)	-	(2,140,013)
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,000,000	8,007,687	31,812,452	43,820,139	(349,308)	43,470,831

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

**ТҮМЭН ШУВУУТ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
12-Р САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
Тайлант жилийн татварын өмнөх ашиг		13,877,194	6,521,167
Тохируулгууд:			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	11	3,051,568	2,355,602
Биет бус хөрөнгийн хорогдол	12	16,949	30,248
Биологийн хөрөнгийн хорогдол	13	4,456,929	3,936,330
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз		(119,587)	(18,807)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз)/гарз	25	54,985	(15,837)
Гүүдвیلیйн үнэ цэнийн бууралтын алдагдал	25	-	788,418
Бараа материал данснаас хассаны зардал	24	262,136	259,725
Хүүгийн зардал	17.2	1,003,175	700,186
		22,603,349	14,557,032
Дансны ба бусад авлагын өсөлт		(1,986,196)	(2,117,975)
Урьдчилгаа төлбөрийн (өсөлт)/бууралт		(3,128,377)	1,654,075
Бараа материалын (өсөлт)/бууралт		(499,786)	1,783,116
Дансны ба бусад өглөгийн өсөлт		60,242	1,150,575
Гэрээний өр төлбөрийн (бууралт)/өсөлт		(43,833)	37,234
		17,005,399	17,064,057
Төлсөн орлогын татвар	21.2	(1,861,113)	(1,005,954)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		15,144,286	16,058,103
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдан авсан үндсэн хөрөнгө		(11,236,426)	(9,805,244)
Худалдан авсан биологийн хөрөнгө	13.2	(5,823,534)	(4,599,605)
Худалдан авсан биет бус хөрөнгө	12	(187,140)	-
Үндсэн хөрөнгө худалдан борлуулснаас орж ирсэн мөнгө		280,000	92,172
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(16,967,100)	(14,312,677)
